

Written by hanoi

Friday, 17 November 2017 03:09 - Last Updated Friday, 17 November 2017 03:23

---

There are no translations available.



Вьетнамын Шадар сайд богоод Гадаад хэргийн сайд Фам Бинь Минь энэ сарын 16-ны одор Элчин сайд Д.Билэгдоржийг хүлээн авч уулзан, Монгол, Вьетнамын уламжлалт найрсаг харилцаа, хамтын ажиллагааны талаар дэлгэрэнгүй санал солилцов.

Хоёр улсын улс төрийн харилцаа идэвхжиж, дээд, ондор твшний харилцан айлчлал тогтмолжсоныг талууд тэмдэглээд, цаашид худалдаа, эдийн засаг, хоронго оруулалт зэрэг салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэхээр санал нэгдэв. Онгорсон хугацаанд хамтран хэрэгжүүлсэн айлчлал, арга хэмжээнд сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлж, талуудын хэлэлцэн тохирсон асуудлыг ажил хэрэг болгоход анхаарч ажиллахаар тогтов. Тухайлбал, 8 дугаар сард Улаанбаатар хотноо болсон Монгол, Вьетнамын ЗГХК-ийн 16 дугаар хуралдаанаар худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, Монголоос гүн холдоосон мах, махан бүтээгдэхүүн, Вьетнамаас тахиа, гахайны гүн холдоосон мах, далайн бүтээгдэхүүнийг харилцан нийлүүлэхээр тохирсныг урагшлуулах нь зүйтэйг тэмдэглэв.

